

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Өдөр +25
Шөнө +15

УЛС ТӨР

А.ГАНБААТАР: НАМЫНХАА
БАЙРААР Ч ОРЖ ЧАДАХГҮЙ ЯВНА

V нүүрт

ДЭЛХИЙ

МҮН ЖЭ ИН: СОЛОНГОСЫН ХОЙГТ
ДАХИН ДАЙН ГАРАХГҮЙ

IV нүүрт

Дугаарын 60 мөр

Нотариатыг халах цаг болсон

Н.ПУНЦАГБОЛД

Нийслэлийн Засаг дарга С.Батболд иргэдэд учирдаг дарамт, хүнд суртлыг арилгах зорилгоор нэг захирамж гаргалаа. Тэр нь нийслэлийн төр, захиргааны байгууллагуудаар үйлчлүүлэх иргэн, хуулийн этгээд иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээ болон холбогдох бусад албан бичгийг эх хувиар нь авчирсан тохиолдолд хуулбарыг нотариатаар баталгаажуулахыг шаардах явдлыг таслан зогсоох тухай захирамж. Улмаар нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллага, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллагуудад үүрэг болголоо.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

Өнгөрсөн долоо хоногт Монгол Улсын Ерөнхийлөгч Элчин сайдуудыг хүлээн авч уулзаж, МАН-ын удирдах зөвлөл хуралдаж, УИХ дахь АН-ын бүлэг УИХ-ын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулахыг шаардаж, бас нэлээд дуулиан шуугиан бүхий асуудлууд өрнөж өнгөрлөө. Ингээд эндээс хамгийн их сонирхол татахуйц ярилцлагуудаас тоймлон хүргэе.

3.Энхболд: Гуравхан жилийн дотор монголчуудын өрийг тэглэх боломжтой

/Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга/

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгыг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байхад нь АН-аас "Иргэдийн тэр дундаа малчны, оюутны, цалингийн, тэтгэврийн зээлийг тэглэх боломжийг хамгийн түрүүнд судлаарай" хэмээн албан бичиг өргөн барьж байсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

Дэлхийн яруу найрагчдын их хуралд Ерөнхийлөгч илгээлт явууллаа

Дэлхийн яруу найрагчдын 37 дугаар их хурлын нээлт өчигдөр Төрийн ордонд боллоо. Тус их хуралд оролцогчдод хандан Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга илгээлт явуулсныг Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулан уншиж сонордуулав. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга илгээлтдээ "Дэлхийн Яруу найрагчдын 37 дугаар их хурлын зочид төлөөлөгчид, эрхэм хүндэт яруу найрагчид, уншигч та бүхний амгаланг айлтгая. "Байгалийн оюун санаа ба хүмүүний сэтгэлийн байгаль" агуулгын дор болж байгаа Монгол дахь дэлхийн яруу найргийн өдрүүд хийгээд Дэлхийн яруу найрагчдын 37 дугаар их хурал, Данзанравжаа Олон улсын яруу найргийн наадам нь өнөөдөр манай гариг дэлхий хийгээд хүн төрөлхтний өмнө тулгараад буй байгаль экологи, хүний сэтгэл хоёрын хоорондох оюун санааны маш нандин холбоо шүтэлцээг хөндөж байгаа нь чухам XXI зууны хүн төрөлхтөнд тулгараад байгаа амин чухал асуудал мөн.

Үргэлжлэл нь II нүүрт

OMEGA

Speedmaster 38 mm

Ω OMEGA

OMEGA Boutique: Central Tower, Sukhbaatar Square, 2nd Floor, Tel: 9963-9494

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2438.00	2452.00	ФУНТ 3107.00	3184.00
ЕВРО	2843.00	2904.00	РУБЛЬ 40.20	42.20
ИЕН	22.12	22.52	ЮАНЬ 364.00	367.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



СПОРТ

ДИЙЛДЭШГҮЙ ЗИДАН,
ДИЙЛДЭШГҮЙ “РЕАЛ МАДРИД”

VI нүүрт

ЧӨЛӨӨТ БӨХИЙН ДАШТ
ДАВАА ГАРАГТ ЭХЭЛНЭ

VIII нүүрт

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Олон улсын өртөөт марафонд Онцгой байдлын хэлтсийн гал сөнөөгч тэргүүлжээ

Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн биеийн тамир, спортын хороо, БНХАУ-ын “Grand china sport” холбооноос хамтран зохион байгуулсан “Dawa” цомын нэрэмжит “Үзэсгэлэнт Улаанбаатар-2017” олон улсын өртөөт марафон гүйлтийн анхдугаар тэмцээн болов. Тус тэмцээн “Жуулчин”, “Гэр бүл”, “Найзууд”, “Сэтгэлд хоногшсон Улаанбаатар” гэсэн дөрвөн ангилал, төрлөөр явагдсан бөгөөд “Гэр бүл”-ийн ангилалд Нийслэлийн Онцгой байдлын газрын Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн

Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр ангийн гал сөнөөгч, ахлах ахлагч Долгорсүрэнгийн Тэмүүжин эхнэр хүүгийн хамт амжилттай оролцож Тэргүүн байр эзлэн Алтан медаль, цом, өргөмжлөл, БНХАУ-ын үзэсгэлэнт газруудаар гэр бүлээрээ үнэ төлбөргүй аялах эрхийн бичиг гарджээ. Ахлах ахлагч Д.Тэмүүжин нь марафон гүйлтийн төрлөөр 14 жил хичээллэж байгаа бөгөөд 2015, 2016 онд “Улаанбаатар-марафон” Олон улсын тэмцээний дэд байрт хоёр жил дараалан шалгарч, мөнгөн медаль хүртэж байжээ.

АМЖИЛТЫН ЭЗЭД

Н.ЦЭВЭГНЯМ: ЯДАЖ НАЛАЙХДАА ЯМАР НЭГ ЗҮЙЛ ХИЙЖ ӨГӨХ ЮМСАН ГЭЖ БОДОЖ ЯВДАГ



Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Японы 2000 жилийн түүхт мэргэжлийн сумогийн ертөнцөд гадны улс орны бөхчүүд хүч бяраа шавхан өрсөлдөж буй. Тэдний дундаас монгол бөхчүүд тэсвэр хатуужил, ур ухаанаараа хэдийнэ ялгараад амжсан ч, өнөөдрийг хүртэл нэг ч дэвжээний багш төрөөгүй байлаа.

Үргэлжлэл нь VII нүүрт

Хаданд авиралтын УАШТ-д нийгэмлэг, клубууд оролцох эрхтэй

Монголын Уулчдын үндэсний холбоо хаданд авиралтын 2017 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Уулын спортын Олон улсын хэмжээний мастер Д.Чадраабалын нэрэмжит болгон зохион байгуулахаар болжээ. Тэмцээн энэ сарын 27-28-нд Төв аймгийн Борнуур сумын нутагт, “Дуган хад” жуулчны баазад болох юм байна. Уулын спортын төрөл болох байгалийн хаданд авиралтын төрлийг олон нийгэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, сонирхогч, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, өндөр зэрэгтэй тамирчдын авиралтын ур чадварыг дээшлүүлэх болон дэлхий, тив, олон улсын тавцанд өрсөлдөх шилдэг тамирчдыг илрүүлэн сонгон шалгаруулах, залгамж халааг бэлтгэх, олон улсын тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах, тамирчдын чансааг тодорхойлох оноо өгөх, тэмцээний удирдлага, зохион байгуулалтыг чанаржуулах, клубуудыг тухайн төрлөөр дагнан хичээллэх тамирчидтай болоход дэмжлэг

үзүүлэх нь тэмцээний гол зорилго ажээ. Аймаг, сум, дүүргүүд эхлээд аварга шалгаруулах тэмцээнээ зохион байгуулж, улмаар шигшээ баг бүрдүүлэх эсвэл бие даасан нийгэмлэг, клубууд энэ тэмцээнд оролцох эрхтэй юм байна. Тухайлбал, нийслэлээс их дээд сургууль, зэвсэгт хүчний байгууллагууд, уулын спортын холбоод, нийгэмлэг, клубууд бие даан оролцох гэнэ.

Тэмцээний төрөл

- 8.1. Хурд
- 8.2. Техник

Насны ангилал

- 9.1. Хурдны төрөлд:
 - 9.1.1. Өсвөр нас – 8-13 нас /2004-2009 он/
 - 9.1.2. Залуучууд нас – 14-19 нас /1998-2003/
 - 9.1.3. Насанд хүрэгчид – 20-35 нас /1982-1997/
 - 9.1.4. Ахмад нас – 36-аас дээш нас /1982-оос өмнө/
- 9.2. Техникийн төрөлд:
 - 9.1.5. Залуучууд нас – 14-19 нас /1998-2003/
 - 9.1.6. Насанд хүрэгчид – 20-35 нас /1982-1997/
 - 9.1.7. Ахмад нас – 36-аас дээш нас /1982-аас өмнө/

Э.Халиунболд хүрэл медаль хүртлээ

АНУ-ын Лос Анжелес хотод Дэлхийн цагдаагийн спортын их наадам болж, өчигдөр өндөрлөлөө. Наадамд оролцож буй манай улсын баг бүрэлдэхүүн тэмцээн эхэлсэн өдрөөс хойш бүх төрөлд медаль хүртээд байгаа. Тэгвэл амжилтын буухиа тэмцээний сүүлийн өдрүүдэд ч үргэлжилсэн юм. Тодруулбал хоёр хоногийн өмнө Глен Хеленд болсон мотокроссын “OPEN PRO” ангилалд Нийслэлийн цагдаагийн газар, “Хүч” спорт хорооны тамирчин Э.Халиунболд хүрэл медаль хүртжээ. Э.Халиунболд өмнө нь уг тэмцээнээс алт, мөнгөн медаль хүртэж байсан юм. Уг тэмцээний тухайд 70 гаруй орны 10000 гаруй тамирчин спортын 60 төрөлд хурд хүч, авхаалж самбаагаа сорьдог билээ. Манай улсын төлөөлж оролцож буй “Хүч” спорт хорооны шигшээ баг жүдо бөх, буудлага, мотокросс, хүндийг өргөлт, сонгомол болон чөлөөт бөх, дугуйн спорт, жигүүрчлэлт төрөлд медаль аваад байгаа юм.



“Тайпэй-2017” наадмын есөн төрөлд манай тамирчид өрсөлдөнө

Дэлхийн оюутны спортын “Тайпэй-2017” зуны XXIX Универсиад их наадам энэ сарын 19-31-нд Тайванийн Тайпэй хотноо болно. Энэхүү наадамд 162 орны 12 мянга 500 төлөөлөгч оролцож, спортын 19 төрлөөр өрсөлдөж бөгөөд манай улсаас 76 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож, спортын есөн төрөлд өрсөлдөх юм байна. Энэ удаагийн наадамд эх орноо төлөөлөн оролцох баг, тамирчдад шаардагдах зардлын

тодорхой хувийг БСПУСЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар шийдвэрлэжээ. Тодруулбал, 59 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэж, баг, тамирчдад дэмжсэн байна. Монгол Улсын баг тамирчид өнгөрсөн 52 жилийн хугацаанд дэлхийн Универсиад наадмын спортын долоон төрлөөс 11 алт, 14 мөнгө, 25 хүрэл, нийт 50 медаль хүртэж байв.

МЭДЭЭЛЭЛ

“Хакүхо цом” Яармаг дахь дэвжээнд болно

Монгол Улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой, Японы Мьяконожё хоттой холбоо тогтоосны 25 жилийн ой энэ онд тохиож буйтай холбогдуулан тус хотын иргэдийн хандиваар Яармагт байрлах “Мөнххада” компанийн гадаа талбайд Монгол дахь мэргэжлийн сумогийн дэвжээг барьж дуусгасан билээ. Дэвжээний нээлт өнгөрсөн сарын 27-нд болж, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат тамирчин, Мэргэжлийн сумо бөхийн 69 дэх Их аварга

Хакүхо М.Даваажаргал оролцсон юм. Тэрбээр мэргэжлийн сумогийн 39 дэх түрүүг авч, нийт давааны тоогоо 1050 болгон шинэ амжилт тогтоосон үйл явдалтай давхцаж буйд ихэд бэлгэшээж буйгаа хэлээд Монгол Улсын мэргэжлийн сумогийн их аваргууд энэ дэвжээнээс төрөн гарахыг ерөөсөн. Харин Монгол Улсын гавьяат тамирчин, Кёкүшүзан Д. Батбаяр хэлэхдээ, “Японд сайн барилдаад зогсохгүй Монголд байгаа залуучууд, хүүхэд багачуудыг дэмжиж дараа дараагийн якузонууд гараасай гэсэн

үүднээс энэхүү дэвжээг М.Даваажаргал аварга төсөл гаргаж улмаар Японы дэвжээ барьдаг мэргэжлийн хүмүүсийг Монголд урьж, долоо хоногт барьж дуусгаж байгаа юм. Дэвжээний цагаан хүрээ, дэрсэн хүрээг Японоос онгоцоор явуулсан. Японы мэргэжлийн “Негорожу” хотын дэвжээ анх удаагаа Монгол Улсад бэлэн боллоо” гэсэн байдаг. Тэгвэл энэ жилийн Аваргын нэрэмжит “Хакүхо цом” Сумо бөхийн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээнийг тус дэвжээн дээр зохион байгуулах юм байна.

ХӨЛБӨМБӨГ

Кроос "Реал"-ын төлөө 150 тоглолтод оролцсон дөрөв Герман хөлбөмбөгч

Испанийн Супер цомын тэмцээний хариу тоглолт өнгөрсөн лхагва гарагийн шөнө болсон. Энэ тоглолтод Герман хагас хамгаалагч Тони Кроос оролцсон юм. Ингэснээр тэрбээр "Реал Мадрид"-ын төлөө дор хаяж 150 тоглолтод оролцсон Германы дөрөв дэх хөлбөмбөгч боллоо. Энэ

үзүүлэлтээр Ули Штиликэ тэргүүлдэг бөгөөд тэрбээр Эзэн хааны багийн төлөө 308 тоглолтод оролцож байжээ. Харин хоёрдугаарт Сами Хедира 161 тоглолтод оролцсоноороо бичигддэг байна. Тэгвэл Месут Өзил 159 тоглолтод оролцож байжээ.

ДИЙЛДЭШГҮЙ ЗИДАН, "РЕАЛ МАДРИД"



"Манчестер Сити" Эвансын төлөөх саналаа өсгөнө

Английн "Манчестер Сити" клуб нэг нутгийн баг болох "Вест Бромвич"-оос хоёр жилийн дараа чөлөөт агент болох төвийн хамгаалагч Жонни Эвансыг худалдаж авахаар гэж байна. Өдгөө 29 настай хамгаалагчийн төлөө "Сити" 18 сая фунт санал болгосон ч "Вест Бромвич" татгалзсан. Тиймээс "Хотынхон" үнийн дүнгээ нэмэгдүүлж санал хүргүүлэх гэж байгаа ажээ. "Вест Бромвич"-ын хувьд Эвансын гэрээг сунгаж, долоо хоногт 85 мянган фунт стерлингийн цалин өгөхөөр санал болгож байгаа юм байна.



"Эвертон" Сигурдссоныг 45 сая фунтээр худалдаж авлаа

Английн "Эвертон" клуб "Соунси"-гийн гол хөдөлгүүр болж байсан Исланд хагас хамгаалагч Гюльфи Сигурдссоныг авснаа зарлалаа. Эдүгээ 27 настай тамирчин шинэ багтайгаа 2022 оны зун хүртэл гэрээ байгуулж,

гарын үсэг зуржээ. "Эвертон" түүнийг клубынхээ түүхэн дэх хамгийн өндөр үнээр авч байгаа аж. Sky Sports-ын мэдээлж байгаагаар "Соунси"-д 45 сая фунт стерлинг төлж байж түүнийг авсан юм байна.

Ибра "Манчестер Юнайтед"-ын тоглогч-дасгалжуулагч болж магадгүй

"Манчестер Юнайтед"-ын довтлогч Златан Ибрагимович багтаа тоглогч-дасгалжуулагчийн хувиар үлдэж, гэрээ хийх гэж байгаа талаар The Independent мэдээллээ. "Улаан чөтгөрүүд"-ийн дасгалжуулагч Жозе Моуриньо эдүгээ 35 настай Швед эрийг туршлагатай төдийгүй тоглогч, дасгалжуулагчийн хооронд холбоос болж чадна гэж үзэж байгаа аж. Тус сонин мэдээлж байгааг Моуриньо аль хэдийнэ Ибрагатай энэ асуудлаар ярилцаж, санал болдоо солилцсон юм байна. Ибрагийн гэрээ энэ зун дууссаны дараа "Манчестер Юнайтед"-аас шинийг санал болгосон. Гэвч тэрбээр өвдөгний бэртлээ эдгэрэх хүртэл гэрээгээ сунгахгүй байхаар шийдэж, татгалзсан хариу өгчихөөд байгаа билээ.



"Наполи" эхний тоглолтодоо хожлоо

Аваргуудын лигийн урьдчилсан шатны хүрээнд өнгөрсөн лхагва гарагийн шөнө таван тоглолт боллоо. Тэр дундаас хамгийн анхаарал татсан тоглолт нь Италийн "Наполи" болон Францын "Ницца" клубын хооронд болсон. Италид болсон энэхүү тоглолтод талбайн эзэд өрсөлдөгчөө 2:0-ээр буулгаж авлаа. Ингэснээр Аваргуудын лигт ороход нэг алхам ойртлоо. Тоглолтын 13 дахь минутад Мертенс гоолдож, тооны харьцааг нээсэн. Харин 70 дахь минутад Жоржиньо торгуулийн цохилтоос нэгийг нэмж, багийнхаа хожлыг баталгаажуулжээ. Хоёр багийн хариу тоглолт долоо хоногийн дараа Францад болно. Эхний тоглолтод Шотландын "Селтик" клуб талбайдаа Казахстаны "Астана"-г хүлээж авч, 5:0-ээр шүүрдлээ. Ингэснээр "Селтик" Аваргуудын лигт орох нь тодорхой болж байх шиг байна. Хариу тоглолтод таваас олон гоолын зөрүүгээр хожигдоно гэж бараг л байхгүй.

БУСАД ТОГЛОЛТЫН ҮР ДҮН
Олимпиаос 2-1 Риека
Хапозль Беер-Шева 2-1 Марибор
Истанбул 1-2 Севилья

Н.ПУНЦАГ

Испанийн Супер цомын тэмцээний хариу тоглолт өнгөрсөн лхагва гарагийн шөнө болж өндөрлөлөө. Энэ тоглолтод талбайн эзэн "Реал Мадрид" клуб заналт өрсөлдөгч "Барселона"-г 2:0-ээр буулгаж авч, ямархуу хүчирхэг байгаагаа харуулсан юм. Эхний тоглолт "Камп ноу"-д болоход эзэн хааны баг Каталонь нэр төрийг талбайд нь 1:3-аар буулгаж авчихаад байсан. Ийнхүү хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 5:1-ээр бүтниргэлээ. Эхний тоглолтод "Реал"-аас Роналдо, Асенсио нар гоолдсон. Харин "Барса"-гаас Месси нэр төрийн ганц гоол оруулсан юм. Тэгвэл хариу тоглолтод өнөөх л Асенсио дахин гоолдсон бол Бензема туршлага зааж нэгийг нэмсэн билээ. Ийнхүү "Реал Мадрид" 2017 оны календарийн жилд дөрвөн цом хүртэж, ялгуулсан ялалтуудыг байгууллаа. Одоо тэднийг дийлдэшгүй "Реал Мадрид" хэмээн тодотгож байна. "Реал"

...Испанийн Супер цомын тэмцээнтэй холбоотой бас нэгэн рекорд амжилт гарсан. Тэр нь мөн л "Реал"-тай холбоотой юм. Учир нь "Реал" талбайдаа "Барселона"-г 2:0-ээр хожсоноор 68 тоглолт дараалан гоол оруулж чадлаа. Энэ нь Европын топ-5 лигт өмнө нь гарч байгаагүй шинэ дээд амжилт болоод байна...

өнгөрсөн хавар Испанийн Ла лигт түрүүлсэн. Улмаар Аваргуудын лигт түрүүлж чадсан бол шинэ улирлын эхэнд Европын болон Испанийн Супер цомд түрүүлж чадлаа. Тэгэхдээ "Манчестер Юнайтед" болон "Барселона" гэсэн агуу түүхтэй, том багуудыг хожиж чадсан. Харин Испанийн Супер цомд түрүүлсэн нь тэднийг араасаа маш олон рекорд амжилтыг дагуулахад хүргэсэн юм.

Зидан "Реал"-ын хамтаар хоёр улиралд долоон цом хүртлээ

2016 оны нэгдүгээр сарын 4-ний өдөр Зинеддин Зидан Испанийн агуу баг болох "Реал Мадрид"-ын ахлах дасгалжуулагчаар томилогдсон билээ. Түүнээс хойш тэрбээр "Реал"-ын хамтаар өргөж болох бүхий л цомыг өргөж байна. Тэгвэл тэрбээр Испанийн супер цомд түрүүлснээр "Реал Мадрид"-ын хамтаар долоо дахь цомоо өргөлөө. 2016 онд тэрбээр "Реал"-ын хамтаар Аваргуудын лиг, Европын Супер цом, Клубүүдийн дэлхийн аваргад түрүүлсэн. Тэгвэл энэ жил Ла лиг, Аваргуудын лиг болоод Европ, Испанийн Супер цомд түрүүлээ. Ийнхүү "Реал Мадрид"-ын хамтаар долоон цом өргөж явсан



Висенте Дель Боскегийн амжилттай зэрэгцэж байгаа юм. Одоо түүний өмнө "Реал"-ыг удирдаж найман цом хүртэж явсан Луиса Моловнигийн амжилт байна. Харин оргилд нь 14 цом хүртсэн агуу дасгалжуулагч Мигель Муньос байгаа. Зидан багтайгаа хоёр жил хагасын гэрээ байгуулчихсан. Тэгэхээр энэ ондоо багтаад Клубүүдийн ДАШТ-д түрүүлж, найм дахь цомоо хүртэх магадлал өндөр. Цаашлаад агуу Мигель Муньосын амжилтыг эвдэх ч боломж байна.

"Реал" хоёр дахь удаагаа нэг календарийн жилд дөрвөн цом хүртлээ

Испанийн Супер цомд түрүүлснээр "Реал Мадрид" бас нэгэн рекордоо давтсан юм. Энэ нь нэг календарийн жилд дөрвөн цом хүртсэн явдал. 2014 онд "Реал" дөрвөн цом өргөж байсан бол гурван жилийн дараа давтлаа. Гэхдээ энэ жил Испанийн ла лиг, Аваргуудын

лиг болоод Супер цомуудад түрүүлж байгаа юм. Цаашлаад энэ ондоо багтаж Клубүүдийн ДАШТ-нд түрүүлбэл өнөө жил таван цом өргөх учиртай. Мөн цагтаа "Барселона"-гийн тогтоож байсан зургаан цомд түрүүлсэн амжилтад хүрэх боломж ч Зиданы удирдсан "Реал Мадрид" клубт байна.

"Реал" 68 тоглолт дараалан гоол орууллаа

Испанийн Супер цомын тэмцээнтэй холбоотой бас нэгэн рекорд амжилт гарсан. Тэр нь мөн л "Реал"-тай холбоотой юм. Учир нь "Реал" талбайдаа "Барселона"-г 2:0-ээр хожсоноор 68 тоглолт дараалан гоол оруулж чадлаа. Энэ нь Европын топ-5 лигт өмнө нь гарч байгаагүй шинэ дээд амжилт болоод байна. Харин "Барселона"-тай холбоотой нэг сөрөг үр дүн гарсан нь 2011 оноос хойш анх удаа "Реал"-ын хаалганд гоол оруулж чадсангүй. Энэ хугацаанд хоёр баг 24 удаа учраа таарахад "Барса" бүгдэд нь гоолдож байжээ.

СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭД



Н.ЦЭВЭГНЯМ: Ядаж Налайхдаа ямар нэг зүйл хийж өгөх юмсан гэж бодож явдаг

Үргэлжлэл.
Түрүүч нь V нүүрт

Харин Кёкүтэнхо Цэвэгниам 2015 онд Монголоос гаралтай анхны ояката болж, энэ оны зургадугаар сард Томозүна дэвжээгээ залгамжлан авсан юм. Одоо тэр өөрийн гэсэн дэвжээтэй, өөрийн гэсэн шавь нартай багш болсон билээ. Түүний хувьд өнгөрөгч башё Томозүна дэмжээний багш болсноос хойших анхны чухал тэмцээн байсан юм.

Тэгвэл Кёкүтэнхо Цэвэгниамыг ояката болсноос хойших анхны ярилцлагыг "Reuters" авчээ. 30 насандаа буюу 2005 онд Японы иргэншил авсан тэрбээр анх сүмогоор хичээллэж эхэлсэн тухайн үе, тулгарч байсан бэрхшээл, ялан дийлсэн туршлагаасаа хуваалцаж, сонирхолтой ярилцлага өрнүүлснийг уншигчиддаа орчуулан хүргэж байна.

Түүний туулсан зам хэдий дардан байгаагүй ч, ирээдүйд ояката болно гэсэн хүсэл мөрөөдлийнхөө төлөө Японы сүмогийн холбооноос тавьсан нөхцлийг биелүүлж, тус улсын иргэн болсон байдаг. Түүний эхнэр нь ч япон бөгөөд нэг хүү, хоёр охинтой ажээ. Ингээд түүний ярилцлагыг хүргэе.

нь бас зөвшөөрсөн юм. Башё дуусаад бүсийн барилдаанууд руу явчихсан хүн ч цөөхөн байсан үе. Бид "Кёошюүжё" гэх сүмогийн сургуульд явдаг байсан юм. Тэгээд "энэ хичээл дуусчихвал бүр л хэцүүднэ" гэж бодоцгоосон байлаа. Яг тэр үед манай дээд үеийнхэн бүсийн барилдаанд яваагүй байсан юм. Тэгээд л оргосон доо. Шөнө дундын үед өрөөнөөсөө оргоод өглөө Монголын Элчин сайдын яаманд очсон. Бид тавуулаа зугтаасан байсан юм. Тэндээс хоёр нь дэвжээ рүүгээ буцаж, гурав нь Монгол руу явсан. Монголд очоод хоёр сар орчим болж байтал манай дэвжээний ояката ирдэг юм байна. Тэр үед "Буцаж очоод илүү хүчтэй болох хэрэгтэй" гэж хэлэхэд нь би "ойлгооло" гээд л хамтдаа Япон руу буцаж байлаа. Ингэж л хоёр дахь удаагаа сүмод ирж байсан юм. Тэр үед өмнө нь нэг удаа ирчихсэн байсан учраас анхныгаа бодвол сүмо гэж ямар ертөнц болохыг ойлгодог

...Хүнийг хөгжүүлдэг спорт. Үр дүн нь цаг тутамд харагддаг. Тухайн хүний тэсвэр хатуужил ямар байхаас хамаарч, энэ спортод хязгаар үгүй. Багийн спортод нэг хүн хэчнээн сайн байлаа ч, амжилт гаргахад бэрх. Харин сүмод бол тийм биш...

болсон байв. Тиймээс арай амар байсан.

-Түүнээс хойш сүмо бөхийн спортоор энэ олон жил хичээллэхэд хүргэсэн мотиваци нь чухам юу байсан юм бол?

-Аав өвдсөн, би гэрлэсэн ч байлаа. Дараа нь хүүхэд ч төрж, янз бүрийн л шалтгаан цаг тутамд гарч ирж байсан даа. Харин сүүлдээ башёд түрүүлсний дараа сүмог орхих тухай бодохоо больсон.

-2014 онд та түрүүлсэн. Тэр үед таныг улам их хүчтэй болгож байсан гол хүчин зүйл нь юу байсан юм бэ?

-Дэвжээгээ сольсон минь маш том нөлөө үзүүлсэн юм болов уу гэж боддог. Оошима дэвжээгээс Томозүнад шилжиж очсоны дараа анхны башёд надад зодог тайлаад ояката болох сонголт байсан ч, үргэлжлүүлэн барилдахыг нь сонгосон. Гэтэл тэр үед хүмүүс "Олигтой амжилт гаргаагүй байж, больсон нь дээр байсан юм даа" гэж хэлж билээ. Тэр үг надад хүнд туссан. Тэгээд л заавал яана гэж бодоод орсон. Юунаас болсон гэдгийг нь сайн мэдэхгүй ч тэр башёд түрүүлчихсэн.

-Тамирчин хүний хамгийн том айдас нь бэртэл гэмтэл боддог. Гэтэл та нэг ч удаа бэртэж гэмтэлгүй 40 нас хүртлээ барилдсан шүү дээ. Үүний нууц нь юу вэ?

-Уг гарвал, төрүүлж өсгөсөн ээж аавын минь ач юм уу даа. Хүмүүсийн өгсөн зөвлөгөөг дагаж, бас өөрөө мэдэрч бэлтгэл сургуулигтаа хийдэг байсан. Янз бүрийн л хүчин зүйл нөлөөлсөн байх. Нууц нь энэ гээд хэлж чадахгүй нь. Ганц зүйлээс шалтгаалаагүй учраас тэр.

-Сүмо гэдэг спортыг ояката хүний байр сууринаас тайлбарлаач гэвэл та юу хэлэх вэ?

-Хүнийг хөгжүүлдэг спорт. Үр дүн нь цаг тутамд харагддаг. Тухайн хүний тэсвэр хатуужил ямар байхаас хамаарч, энэ спортод хязгаар үгүй. Багийн

спортод нэг хүн хэчнээн сайн байлаа ч, амжилт гаргахад бэрх. Харин сүмод бол тийм биш. Ганц хүнээс л шалтгаалдаг. Тийм учраас зогсолтгүй хичээх хэрэгтэй. Дөнгөж очигдөр дэмжээнд ирсэн хүүхэд 10, 20 жил барилдсан хүнтэй нэг газарт хамт амьдрах боломжтой байдаг учраас суралцах зүйл маш их.

-Японы талаар та одоо ямар бодолтой байдаг вэ. Анх ирж байсан тэр үеэс хойш Японы талаархи таны үзэл бодол өөрчлөгдсөн үү?

-Хүмүүс нь нөхөрсөг, хичээл зүтгэлтэй. Сүмогийн ертөнцөд бидэн шиг монголчууд гарч ирээд дэргүүр байр суурийг нь эзэлсэн ч, адил тэгш ханддаг. Энэ магадгүй зөвхөн япон хүнд л байх зан чанар юм болов уу гэж боддог. Бусад спортод ч ийм зүйл байх хэдий ч, гадаадын аль нэг улсаас ирээд, тэр спортынхоо төлөө зүтгэж яваа хүнд тэгш боломж олгодог улс дэлхийд ганц Япон л байдаг байх. Шүүмжлэе гэвэл яаж бол яаж л шүүмжилж болно. Гэхдээ надад одоо шүүмжлэх зүйл алга. Гайхалтай л гэж бодож байна. Сүмогийн ертөнцөд энэ олон жил амьдрахдаа үүнийг л их боддоо.

-Таны дараагийн зорилго?

-Шинэ бөхчүүдийг гаргаж ирмээр байна. Нагоя миний ояката болсноос хойших анхны башё учраас амжилттай дуусгачихмаар байна. Нэг, хоёр башё өнгөрөөд ирэхээр аандаа зүт чигээ олчих болов уу гэж бодож байна даа.

-Та Монголоос спортын цол хүртсэн шүү дээ. Эх орондоо ямар хувь нэмэр оруулъя гэж боддог вэ?

-Миний төрж өссөн нутаг Налайх дүүрэгт аав минь бурхан болсон юм. Тиймээс дүүргийнхээ эмнэлэгт таван ширхэг гемодиализын аппарат, ор, тэргэнээр хандивласан. Монгол өргөн уудам нутаг учраас бүгдэд нь туслая гэхэд миний хүч хүрэхгүй байх. Гэхдээ ядаж Налайхдаа ямар нэг зүйл хийж өгөх юмсан гэж

-1992 онд Монголоос зургаан өсвөр насны хүү Японд ирж, мэргэжлийн сүмогоор хичээллэсний нэг нь та. 16-хан настайдаа Японд ирж суралцахад хамгийн хэцүү нь юу байв даа?

-Соёл уламжлал, бэлтгэл сургуулилт, хоол, өөрөөсөө ахмад болон дүү хүмүүстэй харилцах харилцаа. Хэл үсгүй бас хэцүү юм билээ. Уурласан ч ойлгохгүй, сайшааж магтсан ч ойлгохгүй. Дуртай хоолоо ч идэж чадахгүй, сургуулигтын талбайд, хооллохдоо бухимдаад л, амармаар байвч тийм боломж байдаггүй байсан. Орой хамгийн сүүлд унтаж, өглөө бүгдээс түрүүлж босохгүй л бол болдоггүй байж билээ. Энэ л хамгийн хэцүү. 16 настай хүүхэд учрыг нь ойлгохгүй шүү дээ.

-Тэгээд тэвчиж чадалгүй нэг удаа өрөөнөөсөө зугтаж байсан гэсэн. Тэр тухайгаа одоо дурсаач?

-Бид зургаагийн нэг "ерөөсөө болих уу" гэж хэлэх үед бусад



МЭДЭЭЛЭЛ

Хакүхо Японы "Ард түмний гавьяат" болж магадгүй

Мэргэжлийн сүмо бөхийн 69 дэх аварга Хакүход Японы "Ард түмний гавьяат" шагналыг хүртэж магадгүй гэнэ. Энэ талаар Японы Споничи сонинд анхлан мэдээлжээ.

Засгийн газартай холбоотой нэгэн эх сурвалж иймэрхүү яриа хэлэлцэгдэж байгааг ч нотолсон байна. Сонины газраас 100 хүний дунд энэ талаар санал асуулга явуулахад 68 нь дэмжсэн харилт өгсөн ба 26 эсэргүүцэж, зургаа нь түтгэлзсэн байна. Түүнээс өмнө Тайхо, Чинёофүжи зэрэг аваргууд энэхүү шагналыг гардаж байжээ.

ХАКҮХО АВАРГЫН ДАРААГИЙН ЗОРИЛТ:

- Дээд зиндаанд 1000 даваа авсан цор ганц бөх болох
- Ёкозуна цолтой 63 башё барилдсан Китаноуми аваргын дээд амжилтыг эвдэх зэрэг байгаа билээ. 2020 оны Токиогийн олимп хүртэл барилдах хүсэлтэй түүнд эдгээр амжилтыг эвдэх бүрэн боломж бий.

Монгол бөхчүүдийн эвдсэн сүмогийн амжилтаас

Мэргэжлийн сүмогийн зуны тэмцээн буюу Нагоя башёд ёкозуна Хакүхо М.Даваажаргал нийт даваагаа 1050 болгосноор 1988-2011 онуудад дэвжээнд гарахдаа 1047 давсан алдарт оэки Кайогийн дээд амжилтыг эвдсэн билээ. Сүмогийн түүхэнд хамгийн олон даваатай шилдэг 10 бөхийн жагсаалтын зургаад учраа нараа 927 удаа өвдөг шороодуулсан манай ууган сүмочдын нэг Кёкүтэнхо Н.Цэвэгниам бичигддэг ажээ. Хакүхо түүнчлэн макуүчи буюу дээд зиндаанд 2006 оноос хойш 39 дэх тэмцээнд түрүүлсэн юм. Дээд зиндаанд түүнээс олон удаа башёгийн түрүү авсан бөх үгүй. Их аварга Тайхо 1930-1971 онуудад 32, Чинёофүжи 1981-1990 онуудад 31, харин Асашёрюү Д.Дагвадорж 2002-2010 онуудад 25 удаа түрүүлж байжээ. Хакүхо

хамгийн олон буюу 13 башёд нэг ч уналгүй босоо түрүүлсэн бөгөөд энэ үзүүлэлтээр 1936-1943 онуудад найман тэмцээнд босоо аваргалсан Фүгатабаямагаас хол тасарчээ. 2004-2006 онуудад таван удаа нэг ч уналгүй түрүү авсан Асашёрюү Д.Дагвадорж энэ жагсаалтын долоод бичигддэг байна. Дээд зиндааны хамгийн олон барилдаанд давсан бүх цаг үеийн шилдэг бөх бол мөн л Хакүхо. Тэрбээр дээд зиндааны 956 барилдаанд учраа нараа унагажээ. Түүний ард 879 даваатай Кайо жагсдаг бол 697 даваатай Кёкүтэнхо Н.Цэвэгниам 10-т бичигддэг аж. Хакүхогийн эвдсэн өөр нэг дээд амжилт гэвэл тэрээр нэг жилийн зургаан тэмцээний 90 барилдаанд хоёр удаа (2009, 2010 онуудад) дараалан хамгийн их буюу 86 давсан юм. 2005 онд

84 барилдаанд давсан Асашёрюү Д.Дагвадорж удаалдаг байна. Тэмцээний ялагчийг тодруулах нэмэлт барилдаанд хамгийн их барилдаж давсан бөх бол мөн Хакүхо (10-6). Их аварга Таканохана 11 нэмэлт барилдаанд түүнтэй адил арван удаа хүч үзсэн ч тавд нь л учраагаа өвдөг шороодуулжээ. Энэ жагсаалтын зургаад бичигдсэн Асашёрюү Д.Дагвадорж зургаан нэмэлт барилдааны тавд нь давж байсан үзүүлэлтэй. Ийнхүү Хакүхо сүмогийн зургаан дээд амжилтыг эвдээд байгаа билээ. Дахин дөрвөн башёд барилдахад л тэрбээр ёкозуна цолтойгоор хамгийн олон тэмцээнд зодоглоосон үзүүлэлтээр домогт их аварга Китаноумигийн урд гишгэнэ. Ёкозуна цолтойгоор Китаноумин 63, манай сүмогч 60 башё л хүч үзжээ. Үүнээс гадна

Хакүхо дараалан аваргалсан тэмцээний тоогоор (долоо) Асашёрюү Д.Дагвадоржтой тэнцээд байгаа юм. Энд онцлоход, Асашёрюү Д.Дагвадорж нэг жилийн (2004) зургаан тэмцээний бүгдэд нь түрүүлсэн цорын ганц сүмогч билээ. Манай сүмогчдоос өөр нэг дээд амжилт эзэмшигч бол Кёкүтэнхо И.Цэвэгниам. Тэрбээр дээд зиндаанд хамгийн олон удаа барилдсан (1470) бөх юм. Дээд зиндаанд Кайо 1444, Такамияма 1430 удаа хүч үзэж байжээ. Үүнээс гадна тэрбээр сүмогийн дэвжээнд хамгийн олон барилдсан бөхчүүдийн жагсаалтад Ошиогийн дараа (Ошио -1891, Кёкүтэнхо-1870), дээд зиндааны хамгийн олон башёд хүч үзсэн бөхчүүд дунд Кайогийн дараа (Кайо-107, Кёкүтэнхо-99) тус бүр хоёрт бичигддэг ажээ.

ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +25
Шөнө +14

Нөгөөдөр

Өдөр +19
Шөнө +14

Өдрийн зурхай

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал: Жаргал үргэлжид ирнэ

Наран ургах, шингэх: 05.55-19.57



Тухайн өдөр бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнэс эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлзэх буюу засуулахад тохиромжгүй.

Чөлөөт бөхийн ДАШТ даваа гарагт эхэлнэ



Н.БОЛЦ

Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 21-26-нд Францын нийслэл Парис хотноо болох билээ. Тэгвэл дэлхийн аваргад оролцох Монголын шигшээ багийнхан өнгөрсөн лхагва гарагт Парис хотыг зорьсон. Энэ удаагийн эрэгтэйчүүдийн 50, эмэгтэйчүүдийн 29 дэх удаагийн ДАШТ-д чөлөөт бөхийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч Б.Баттулга, гавьяат дасгалжуулагч А.Цэдэнсодном, Ц.Баярсайхан, ОУХМ Б.Батзориг, Ө.Ууганбаяр нарын удирдлага дор эрэгтэй, эмэгтэй бүтэн багаараа оролцох юм. Манай бөхчүүдээс гавьяат тамирчин О.Насанбурмаа хамгийн олон удаа буюу ес дэх удаагаа дэлхийн аваргад тоосоо өргөхөөр болж байна. Гавьяат тамирчин Д.Отгонцэцэг, Г.Мандахнаран зургаа,

Э.Бэхбаяр, ОУХМ О.Үйтүмэн нар тус бүр дөрөв, ОУХМ Э.Нарангэрэл, Б.Шоовдор нар гурав, Д.Гомбодорж, Т.Түвшинтулга, А.Батцэцэг нар хоёр дахь удаагаа ДАШТ-д зодоглоно. Харин ОУХМ Н.Лхамгармаа, Н.Золбоо, Ө.Батзул, П.Орхон, Э.Даваачимэг, Г.Уртнасан гэсэн зургаан тамирчин дэлхийн шилдгүүдтэй анх удаа нүүр тулах юм. Манай эрэгтэй бөхчүүд 1963 он, эмэгтэй бөхчүүд 2001 оноос ДАШТ-д оролцож эхэлсэн бөгөөд зургаан алт, 18 мөнгө, 30 хүрэл, нийт 54 медаль хүртсэн түүхтэй. Энэ удаагийн дэлхийн аваргынхувьд чөлөөтийн барилдаанууд 23-ны өдрөөс эхлэх юм. 23-ны өдөр 55, 58, 63, 75 кг-ын барилдаан болох бөгөөд Э.Даваачимэг, А.Батцэцэг, П.Орхон, Г.Уртнасан нар дэвжээнд гарна. Тэгвэл 24-нд 48, 53, 60, 69 кг-ын тамирчид буюу Э.Нарангэрэл, Д.Отгонцэцэг, Б.Шоовдор, О.Насанбурмаа нар дэвжээнд

гарна. Эрчүүдийн тухайд 25, 26-нд барилдаа юм. 25-нд Э.Бэхбаяр, Т.Түвшинтулга, О.Үйтүмэн, Н.Золбоо нар дэвжээнд гарах бол 26-д Н.Лхамгармаа, Г.Мандахнаран, Д.Гомбодорж, Ө.Батзул барилдахаар байна. Тэмцээний хэсгийн барилдаанууд манай цагаар 16:00 цагт эхлэх аж. Харин финалын барилдаан шөнийн 01:00 цаг эхлэх юм байна. Дэлхийн аваргын өмнө чөлөөтийн тамирчдын чансаа шинэчлэгдэж гарсан. Манай бөхчүүдээс энэ удаагийн чансаанд эрэгтэй, эмэгтэй тус бүр тав, нийт 10 бөх багтсан юм. Эмэгтэйчүүдийн 63 кг-д өнгөрсөн долдугаар сард Польшийн нээлттэй тэмцээн болон Мадридын Гранприд түрүүлж, "давхар цохилт" хийсэн ОУХМ П.Орхон хоёр байр урагшилж, аман хүүүүдсэн. Тэгвэл эрэгтэйчүүдийн 57 кг-д гавьяат тамирчин Э.Бэхбаяр ес, ОУХМ З.Занабазар 14, 70 кг-д гавьяат

тамирчин Г.Мандахнаран 16, 86 кг-д П.Өнөрбат 18, 125 кг-д ОУХМ Нацагсүрэнгийн Золбоо 19, эмэгтэйчүүдийн 55 кг-д гавьяат тамирчин Даваасүхийн

Отгонцэцэг 14, ОУХМ Эрхэмбаярын Даваачимэг 17, 60 кг-д ОУХМ Баатаржавын Шоовдор 12 дугаар байрт бичигдсэн.

ДАШТ-Д ОРОЛЦОХ МОНГОЛЫН ШИГШЭЭ БАГ

Эрэгтэй

- 57 кг: Эрдэнэбатын Бэхбаяр ("Хангарьд" спорт хороо)
- 61 кг: Түмэнбилэгийн Түвшинтулга ("Аваргууд" академи)
- 65 кг: Нармандахын Лхамгармаа ("Алдар" спорт хороо)
- 70 кг: Ганзоригийн Мандахнаран ("Алдар" спорт хороо)
- 74 кг: Доржваанчигийн Гомбодорж ("Сүлд" спорт хороо)
- 86 кг: Оргодолын Үйтүмэн ("Алдар" спорт хороо)
- 97 кг: Өлзийсайханы Батзул ("Хүч" спорт хороо)
- 125 кг: Нацагсүрэнгийн Золбоо ("Хүч" спорт хороо)

Эмэгтэй

- 48 кг: Эрдэнэсүхийн Нарангэрэл ("Хангарьд" спорт хороо)
- 53 кг: Даваасүхийн Отгонцэцэг ("Хасу-Мегастарс" клуб)
- 55 кг: Эрхэмбаярын Даваачимэг ("Хилчин" спорт хороо)
- 58 кг: Алтанцэцэгийн Батцэцэг ("Хасу-Мегастарс" клуб)
- 60 кг: Баатаржавын Шоовдор ("Хилчин" спорт хороо)
- 63 кг: Пүрэвдоржийн Орхон ("Алдар" спорт хороо)
- 69 кг: Очирбатын Насанбурмаа ("Алтай" констракшн)
- 75 кг: Ган-Очирын Уртнасан ("Хилчин" спорт хороо)

ТЭНГИС

КИНОТЕАТР

<p>Annabelle 2</p> <p>10:45 13:00 15:10 17:25 18:20 VP 18:40 19:50 20:50 22:10 23:00</p>	<p>The Dark Tower</p> <p>12:45 14:50 16:20 VP 19:05 21:00 22:50 VP</p>	<p>"Valerian" YCK</p> <p>10:30 16:00 18:20 23:00</p>	<p>"DUNKIRK" YCK</p> <p>12:00 VP 16:50</p>
<p>War for the Planet of the Apes</p> <p>10:40 13:20 15:05 19:40 20:55 22:25</p>	<p>Spider-Man: Homecoming</p> <p>15:50</p>	<p>Despicable Me 3</p> <p>11:20 13:10 17:50</p>	<p>Transformers: The Last Knight</p> <p>13:00</p>

Монголын тамирчид 14 жингийн 12-т нь түрүүлэв

"Монгол туургатан" олон улсын хүүхдийн спортын наадмын чөлөөт бөхийн тэмцээн Сонгинохайрхан дүүргийн спорт цогцолборт мягмар, лхагва гарагт болж өндөрлөлөө. Долоо дахь удаагийн наадамд Монгол Улсын 54, ОХУ-ын Буридаас 11, БНХАУ-ын ӨМӨЗО-ны 13, нийт 78 тамирчин хөвгүүд, охидын тус бүр долоо, нийт 14 жинд өрсөлдөв. Эхний өдөр долоо жингийн барилдаан болоход манай тамирчид зургаад нь түрүүлсэн. Тэгвэл сүүлийн өдөр буюу лхагва гарагт хөвгүүдийн 42, 50, 63, 100, охидын 43, 52, 60 кг-ын жингийн барилдаан болоход Монголын өсвөр үеийн тамирчид зургаан жинд аваргаллаа. Тодруулбал, хөвгүүдийн 42 кг-д Налайх дүүргийн "Голомт" цогцолбор сургуулийн тамирчин М.Мөнхтөгөлдөр, 50 кг-д Буриадын Владимир Ринчинов, 63 кг-д Дархан-Уул аймаг, "Хасу-Мегастарс" клубийн тамирчин О.Сүлдхүү нар түрүүлсэн. Тэгвэл 100 кг-д Байанхонгор аймгийн тамирчин Э.Батмагнай, охидын 43 кг-д "Женко" клубийн тамирчин Д.Отгонжаргал, 52 кг-д тус клубийн Б.Эрдэнэсүвд, 60 кг-д БТСДУС-ийн Т.Оюун-Эрдэнэ нар жин тус бүртээ түрүүлсэн. Ийнхүү Монголын өсвөр тамирчид нутгийн дэвжээн дээрээ 14 жингийн 12-т аваргаллаа. Харин үлдсэн хоёр алтыг нь Буриадын тамирчид хүртсэн юм.

Жудогийн дэлхийн аварга эхлэхэд 10 өдөр үлдлээ

Унгарын нийслэл Будапешт хотноо энэ сарын 28-ны өдөр жудо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болох билээ. Тэгвэл энэхүү тэмцээнд оролцох улс орнууд эхнээсээ мэдүүлгээ өгч эхэлсэн байна. Одоогийн байдлаар дэлхийн 134 орон бөхчүүдээ барилдуулахаа мэдүүлсэн бөгөөд эрэгтэй 482, эмэгтэй 312, нийт 794 жудоч хүч үзэх гэж байна. Манай улсын хувьд эрэгтэй, эмэгтэй тус бүр ес буюу нийт 18 жудочоо барилдуулахаар мэдүүлгээ өгөөд байгаа аж. Олон улсын жудо бөхийн холбооны албан ёсны сайтад мэдээлж байгаагаар бол эрэгтэйчүүдэд 60 болон +100 кг-д манай улс хоёр тамирчин илгээх аж. Харин эмэгтэйчүүдийн ангилалд 52, 57, 63 гэсэн жинд тус бүр хоёр тамирчин барилдуулахаар мэдүүлгээ илгээжээ. Тэр дундаа +100 кг-д Олимпын аварга Н.Түвшинбаяр барилдахаар мэдүүлэгт багтсан байна. Мөн-100 кг-д Л.Отгонбаатар барилдахаар мэдүүлэгт багтжээ.

ДЭЛХИЙН АВАРГАД БАРИЛДАХ ЖУДОЧИД

Эрэгтэй

- 60 кг Д.Амартүвшин, Г.Болдбаатар
- 66 кг Г.Хэрлэн
- 73 кг Г.Одбаяр
- 81 кг О.Ууганбаатар
- 90 кг Г.Алтанбагана
- +100 кг Л.Отгонбаатар
- +100 Н.Түвшинбаяр, Ө.Дүүрэнбаяр

Эмэгтэй

- 48 кг М.Уранцэцэг
- 52 кг Ч.Аззаяа, Б.Хорлоодой
- 57 кг Д.Сумъяа, Л.Энхрийлэн
- 63 кг Б.Ганхайч, Б.Мөнгөнчимэг
- 70 кг Б.Хулан
- +78 Б.Мөнхтуяа